

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН
ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

**/ШҮҮХИЙН БУС ЖУРМААР ӨР БАРАГДУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ/**

ЗАХИАЛАГЧ:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

ГҮЙЦЭТГЭГЧ:

Г.ХАЛИУНАА

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

Нэг.Ерөнхий мэдээлэл

Хоёр.Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцооны тайлан:

- 2.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2.Нэг бүрийн зардлыг тооцох;
- 2.3.Тоон үзүүлэлтийг тооцох;
- 2.4.Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 2.5.Хялбарчлах боломжийг шалгах;
- 2.6.Нэмэлт зардлыг тооцох.

Гурав.Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцооны тайлан:

- 3.1.Шинээр нэмэгдэж байгаа чиг үүргийг тогтоох;
- 3.2.Уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;
- 3.3.Гарах зардлыг тооцох;
- 3.4.Зардлыг нэгтгэн тооцох;
- 3.5.Хувилбарыг нягталж зардлыг бууруулах боломжийг эрэлхийлэх.

Дөрөв.Дүгнэлт, санал

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

/Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл/

Нэг.Ерөнхий мэдээлэл

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл² /цаашид "хуулийн төсөл" гэх/ батлагдснаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан хийв.

Хуулийн төсөл батлагдснаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно.

Хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлохдоо уг хуулийн төслөөр иргэн буюу зээлдэгч нь өр барагдуулах ажиллагааны нэг тал болсон тохиолдолд тодорхой хэмжээний хөлсийг хувийн эрх зүйн гэрээний үндсэн дээр өр барагдуулах албанд төлөхөөр байх бөгөөд үүнээс өөр зардал иргэнд гарахааргүй байх тул зөвхөн шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг эрхлэх хуулийн этгээд болон төрд үүсэх зардлыг тооцохоор боллоо.

Хуулийн төслөөр шинээр бий болж буй үүрэгт зардал тооцогдож байгаа тул бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдол нилээд байсан тул аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

¹Хууль тогтоомжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

²Тус зардлын тооцооны тайланг гүйцэтгэхдээ Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийн эхний хувилбарт үндэслэсэн болно.

ХОЁР.ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Энэ хэсэгт хуулийн төсөл батлагдснаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана. Ийнхүү үүсэх зардлыг аргачлалын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- нэг бүрийн зардлыг тооцох;
- тоон үзүүлэлтийг тооцох;
- нийт зардлын дүнг тооцож гаргах;
- хялбарчлах боломжийг шалгах;
- нэмэлт зардлыг тооцох.

2.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох:

Хуулийн төслөөр хуулийн этгээдэд шинээр үүсч байгаа үүргийн хүрээнд зардлын тооцоог хийх болно.

Хуулийн төсөлд хуулийн этгээдэд зардал үүсгэх дараах шинэ үүрэг үүсэхээр байна. Үүнд:


- Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд өргөдөл гаргаж бүртгүүлэх /Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг/;
- Бүртгэх байгууллагад шаардлагатай тайлан, мэдээ гаргах болон Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банкинд улирал бүр тайлан хүргүүлэх /Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалт/;
- Цахим мэдээллийн сантай байх, өр төлбөртэй этгээдтэй харилцах бүрдээ дуу дүрсний бичлэг хийж хадгалах, гэрээний бүртгэлийг цахимаар байршуулах /Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.7, 16.1.14 дэх заалт, 12 дугаар зүйл /;
- Өрийн тохиролцоо хийх /Хуулийн төслийн 8 дугаар зүйл/.

Дээрх үүргүүдийн мэдээллийн агуулгыг хуулийн төсөлд дараах байдлаар тодорхойлсон байна.

д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Тайлбар
1	Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд өргөдөл гаргаж бүртгүүлэх /Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1, 5.2 дахь хэсэг/;	Хуулийн төсөлд зааснаар Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан маягтын дагуу өргөдөл гаргаж, үүсгэн байгуулагч, эрх бүхий албан тушаалтны мэдээлэл, ажилтны мэдээлэл, салбарын мэдээлэл зэргийг болон бүртгэх байгууллагын баталсан журмын дагуух баримт бичгийг хавсаргах	
2	Бүртгэх байгууллагад шаардлагатай тайлан, мэдээ гаргах болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкинд улирал бүр тайлан хүргүүлэх /Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалт /;	Шаардлагатай тайланг бэлтгэх, хүргүүлэх Шаардлагатай мэдээг бэлтгэх, хүргүүлэх Улирал бүр тайлан бэлтгэх, хүргүүлэх	
3	Цахим мэдээллийн сантай байх, өр төлбөртэй этгээдтэй харилцах бүрдээ дуу дүрсний бичлэг хийж хадгалах, гэрээний бүртгэлийг цахимаар байршуулах /Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.7, 16.1.14 дэх заалт, 12 дугаар зүйл /;	Цахим сан бий болгох, гэрээний бүртгэлийг тухай бүр хийж байршуулах Өр төлбөртэй этгээдтэй харилцах бүрдээ дуу дүрсний бичлэг хийж баримтжуулж цахим санд байршуулах	
4	Өрийн тохиролцоо хийх /Хуулийн төслийн 8 дугаар зүйл/	Өр төлбөртэй этгээдэд мэдэгдэл хүргүүлэх Зээлдүүлэгчид хариу мэдэгдлийг хүргүүлэх Өрийн тохиролцоо хийх	

2.2.Нэг бүрийн зардлыг тооцох:

Энэ шатанд өмнөх шатанд тодорхойлсон хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, түүнийг гүйцэтгэхэд нэг хуулийн этгээдээс зарцуулах мөнгөн зардлыг тооцоолон гаргана. Ингэхдээ дараах дарааллыг баримтална. Үүнд:



Стандарт үйл ажиллагаа болон зарцуулах хугацааг тодорхойлохдоо аргачлалын гарын авлагад заасан стандарт үйл ажиллагааны жишгийг ашиглав.³

Хүснэгт 2

д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
1	Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд өргөдөл гаргаж бүртгүүлэх /Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1, 5.2 дахь хэсэг/;	Хуулийн төсөлд зааснаар Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан маягтын дагуу өргөдөл гаргах	Өргөдөл бичих	3 минут
		Үүсгэн байгуулагч, эрх бүхий албан тушаалтны мэдээлэл, ажилтны мэдээлэл, салбарын мэдээлэл зэргийг болон бүртгэх байгууллагын баталсан журмын дагуух баримт бичгийг хавсаргах	Мэдээллийг цуглуулах	15 минут
			Мэдээллийг хуулбарлах	5 минут
			Хүргүүлэх	1 минут
Нийт хугацаа				26 минут
2	Бүртгэх байгууллагад шаардлагатай тайлан, мэдээ гаргах болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкинд улирал бүр тайлан хүргүүлэх /Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалт /;		Мэдээлэл цуглуулах	15 минут
			Албан бичиг бичих	3 минут
			Хүргүүлэх	1 минут
Нийт хугацаа				19 минут

³Хууль тогтоомжийн тухай хуулийн аргачлал, гарын авлага, Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, Улаанбаатар 2016 он, 243 дугаар тал.

3	Өр төлбөртэй этгээдтэй харилцах бүрдээ дуу дүрсний бичлэг хийж хадгалах, гэрээний бүртгэлийг цахимаар байршуулах /Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.7, 16.1.14 дэх заалт, 12 дугаар зүйл /;	Дуу дүрсний бичлэг хийх	Дуу дүрсний бичлэг хийх	1 минут
			Цахим санд байршуулах	2 минут
			Гэрээний бүртгэл хийх	7 минут
			Цахимаар скандаж оруулах	2 минут
Нийт хугацаа				12 минут
4	Өрийн тохиролцоо хийх /Хуулийн төслийн 8 дугаар зүйл/	Өр төлбөртэй этгээдэд мэдэгдэл хүргүүлэх Зээлдүүлэгчид хариу мэдэгдлийг хүргүүлэх Өрийн тохиролцоо хийх	Өр төлбөр, төлбөртэй этгээдийн талаар судлах, мэдээлэл цуглуулах	30 минут
			Уулзах	10 минут
			Утсаар ярих, эсхүл захидлаар харилцах	5 минут
			Өрийн тохиролцооны мэдэгдэл бэлдэж, явуулах	15 минут
			Хариу мэдэгдлийг зээлдүүлэгчид хүргүүлэх	5 минут
			Тохиролцоо хийлгэх	60 минут
			Нийт хугацаа	

Ажлын хөслийг тооцож гаргахдаа ажилтанд олгох сарын үндсэн цалинг ажиллах хугацаанд хувааж ажлын хөлсийг өдөр, цаг, минутаар гаргана. Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар нэг ажилтанд ногдох сарын дундаж цалин 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар 1328.1 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 203.8 (15.3 %) мянган төгрөгөөр нэмэгджээ.⁴ Уг үзүүлэлтийг зардлын тооцоонд үндэслэл болгов.

Ажиллах хугацааг тооцоолохдоо Хөдөлмөрийн тухай хуульд⁵ заасан хөдөлмөрийн цагийг үндэслэв.

Ажлын хөлс = Үндсэн цалинг : ажиллах хугацаа
1.328.100: 22 өдөр : 8 цаг : 60 минут = 125.7 төгрөг

⁴Үндэсний статистикийн хорооны веб хуудас.

https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=average_wage_mn_2020q4.pdf&ln=Mn

⁵ Хөдөлмөрийн тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

Дээрх үүргийг хэрэгжүүлэхэд нэг хуулийн этгээдэд үүсгэж байгаа зардлыг үйл ажиллагаа тус бүрд зарцуулж буй хугацааг ажлын хөлсөөр үржүүлэх замаар тооцоолох юм.

Хүснэгт 4

д/д	Гүйцэтгэх үүрэг	Зарцуулах хугацаа	Ажлын хөлс	Нэг бүрийн зардал
1	Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд өргөдөл гаргаж бүртгүүлэх /Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1, 5.2 дахь хэсэг/;	26 минут	125.7 төгрөг	3268.2 төгрөг
2	Бүртгэх байгууллагад шаардлагатай тайлан, мэдээ гаргах болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкинд улирал бүр тайлан хүргүүлэх /Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалт /;	19 минут	125.7 төгрөг	2388.3 төгрөг
3	Өр төлбөртэй этгээдтэй харилцах бүрдээ дуу дүрсний бичлэг хийж хадгалах, гэрээний бүртгэлийг цахимаар байршуулах /Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.7, 16.1.14 дэх заалт, 12 дугаар зүйл /;	12 минут	125.7 төгрөг	1508.4 төгрөг
4	Өрийн тохиролцоо хийх /Хуулийн төслийн 8 дугаар зүйл/	125 минут	125.7 төгрөг	1587.5 төгрөг

2.3.Тоон үзүүлэлтийг тогтоох:

Энэ үе шатанд өмнөх үе шатуудад тогтоосон хуулийн төсөл батлагдан гарснаар шинээр болж буй үүргүүдийг хичнээн хуулийн этгээд, жилд хэдэн удаа гүйцэтгэх вэ гэдгийг хуанлийн нэг жилээр тооцоолон гаргадаг.

Энэ үзүүлэлтийг гаргахын тулд тохиолдлын тоо болон давтамжийг холбогдох статистик мэдээ ашиглан тодорхойлж гаргах бөгөөд тэдгээрийн үржвэрээр “тоон үзүүлэлт” нь илэрхийлэгдэх юм.

2021 оны 2 дугаар улирлын байдлаар Монгол Улсад нийт 11 арилжааны банк, 536 банк бус санхүүгийн байгууллага, үүнээс 457 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж байна. Харин нийт 536 банк бус санхүүгийн байгууллагын 497 нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна. 2020 оны байдлаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч болох барьцаалан зээлдүүлэх газар 1000 гаруй байна.

2021 оны эхний хагас жилийн байдлаар иргэний хэргийн анхан шатны шийдвэрлэсэн нийт хэрэг, маргааны **50.1 хувийг** Иргэний хуулийн 281-286 дугаар зүйл дэх зээлийн гэрээний маргаан, банк болон банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээлийн гэрээний маргаан дангаараа эзэлж байх бөгөөд үүнд Иргэний хуулийн 281-286 дугаар зүйл дэх зээлийн гэрээний маргаан 2550, банкны зээлийн маргаан 1517, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн маргаан 1469 буюу нийт 5536 зээлтэй холбоотой маргаан байна.

Эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн нийт үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний мэдээллээс харахад, 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 23,983 үл хөдлөх хөрөнгө барьцаалагч иргэн 56,996 үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ, харин тодорхой тусгай зөвшөөрөлгүй 4137 хуулийн этгээд 91,988 барьцааны гэрээ байгуулсан байгаа нь банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, барьцаалан зээлдүүлэх газраас гадна зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй компани, байнга ашиг олох зорилгоор зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэд олон байгааг илтгэдэг.

Гэхдээ одоогийн байдлаар банк болон томоохон банк бус санхүүгийн байгууллага өөрийн дотоод бүтэцдээ өр барагдуулах нэгжтэй байна. Иймээс энэхүү хуулийн төсөл батлагдсанаар банк, зарим банк бус санхүүгийн байгууллагын дэргэдэх өр барагдуулах албанаас бусад /банк, банк бус санхүүгийн байгууллагын дэргэдэх өр барагдуулах дотоод бүтэц нь өр барагдуулах албаар бүртгүүлэх шаардлагагүй/ хэдэн хуулийн этгээд өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр бүртгүүлэх нь тодорхойлогдох боломжгүй байх тул зөвхөн нэг хуулийн этгээдийн хувьд 1 удаа гарах тоон үзүүлэлтийг тооцохоор болов.

ТОХИОЛДЛЫН ТОО x ДАВТАМЖ = ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Дээрх томъёог ашиглан хуулийн төсөл батлагдснаар шинээр нэмэгдэж байгаа гэж тодорхойлогдсон үүрэг тус бүрд тоон үзүүлэлтийг тогтооё.

Хүснэгт 5

д/д	Гүйцэтгэх үүрэг	Тохиолдлын тоо	x	Давтамж	=	Тоон үзүүлэлт
1	Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд өргөдөл гаргаж бүртгүүлэх /Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1, 5.2 дахь хэсэг/;	1	x	1	=	1

2	Бүртгэх байгууллагад шаардлагатай тайлан, мэдээ гаргах болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкинд улирал бүр тайлан хүргүүлэх /Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалт /;	1	x	4	=	4
3	Өр төлбөртэй этгээдтэй харилцах бүрдээ дуу дүрсний бичлэг хийж хадгалах, гэрээний бүртгэлийг цахимаар байршуулах /Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.7, 16.1.14 дэх заалт, 12 дугаар зүйл /;	1	x	1	=	1
4	Өрийн тохиролцоо хийх /Хуулийн төслийн 8 дугаар зүйл/	1	x	1	=	1

2.4.Нийт захиргааны зардлын дүнг тооцож гаргах:

Энэ үе шатанд өмнөх үе шатанд гаргасан үүрэг тус бүрд ногдох нэг бүрийн зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлснээр гаргах юм.

НЭГ БҮРИЙН ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ x ТООН ҮЗҮҮЛЭЛТ = НИЙТ ЗАРДАЛ

Хүснэгт 5

д/д	Гүйцэтгэх үүрэг	Нэг бүрийн зардал	x	Тоон үзүүлэлт	=	Нийт зардал ⁶
1	Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд өргөдөл гаргаж бүртгүүлэх /Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1, 5.2 дахь хэсэг/;	3268.2 төгрөг	x	1	=	3268.2 төгрөг
2	Бүртгэх байгууллагад шаардлагатай тайлан, мэдээ гаргах болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкинд улирал бүр тайлан хүргүүлэх	2388.3 төгрөг	x	4	=	9553.2 төгрөг

⁶ Нийт хуулийн этгээдэд үүсэх нийт зардал бус, нэг хуулийн этгээдэд үүсэх нийт зардалыг тооцоолов.

	/Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалт /;					
3	Өр төлбөртэй этгээдтэй харилцах бүрдээ дуу дүрсний бичлэг хийж хадгалах, гэрээний бүртгэлийг цахимаар байршуулах /Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.7, 16.1.14 дэх заалт, 12 дугаар зүйл /;	1508.4 төгрөг	х	1		1508.4 төгрөг
4	Өрийн тохиролцоо хийх /Хуулийн төслийн 8 дугаар зүйл/	1587.5 төгрөг	х	1		1 587.5 төгрөг
НИЙТ ЗАРДАЛ						15,917.3 төгрөг

2.5.Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийн талаар:

Шүүхийн бус журмаар өр барагдуулах албыг бичгээр, цахимаар холимог бус цахимаар дагнан бүртгэхэд хуулийн этгээдэд үүсэх зардлыг багасгах, хялбарчлах боломжтой гэж үзэж байна.

Төрийн байгууллагууд хоорондоо мэдээлэл солилцох замаар олж мэдэх боломжтой баримт бичгийг хуулийн этгээдээс шаардахгүй байх нь нотариатаар батлуулах, хуулбарлах, хүргүүлэх, олшруулах зэрэг нэмэлт зардал, хүнд суртал, чирэгдлийг бууруулахад тодорхой нөлөөтэй гэж үзлээ.

Түүнчлэн хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалтад " Өр барагдуулах алба нь бүртгэх байгууллагад шаардлагатай тайлан, мэдээ гаргах болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкинд улирал бүр тайлан хүргүүлэх" гэснийг шаардлагатай эсэхийг нягтлах, учир нь хуулийн төсөлд зааснаар өр барагдуулах алба нь гэрээний бүртгэл хөтөлж, дуу дүрсний бичлэг хийж баталгаажуулан тухай бүр цахим санд оруулах үүрэгтэй тул ач холбогдлын хувьд шаардлагагүй бол тайлан улирал бүр хүргүүлэх үүргийг хуулийн төслөөс хасвал нэг хуулийн этгээдэд холбогдох зардлыг **9553.2** төгрөгөөр хэмнэх боломжтой байна.

2.6.Нэмэлт зардлыг тооцох:

Хуулийн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийн этгээдээс хуульд заасан үүргийг биелүүлэхийн тулд зайлшгүй төлөхөөр хуулиар тогтоосон төлбөр хураамж, тоног төхөөрөмж, материал зэргийг нэмэлт зардал гэсэн ойлголтонд хамруулах юм. Үүнийг нэмэлт зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлэх замаар гаргаж авна. Өмнөх шатанд тодорхойлогдсон үүргүүдэд дараах төрлийн нэмэлт зардал байх гэж үзлээ.

д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүсч болох нэмэлт зардал	Зардлын хэмжээ	Дундаж нэмэлт зардал	Тоон үзүүлэлт	Нийт нэмэлт зардал
1	Цахим сантай байх ⁷	-	-	-	-	-
2	Дуу хураагуур	-	300,000 ⁸	-	1	300,000
3	Зургийн аппарат	-	1,500,000 ⁹	-	1	1,500,000

ДӨРӨВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Хуулийн төслийн хэрэгжилтийг хангахад гол чиг үүргийг хүлээгч байгууллага нь Санхүүгийн зохицуулах хороо байх тул хуулийн төсөл батлагдан гарснаар Санхүүгийн зохицуулах хороонд үүсэх зардал, ачааллыг тооцоолсон болно.

Шинээр нэмэгдэж байгаа чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардал ачааллыг тооцоолов. Хуулийн төсөл батлагдснаар төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцоолохдоо доорх дарааллаар гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Санхүүгийн зохицуулах хороонд шинээр нэмэгдэж байгаа чиг үүргийг тогтоох;
- Уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;
- Гарах зардлыг тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж зардлыг бууруулах боломжийг эрэлхийлэх.

Хуулийн төсөл дэх төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг /ажил үйлчилгээ/, түүний агуулгыг тодорхойлбол:

4.1. Гүйцэтгэх чиг үүргийг тогтоох:

Хуулийн төслөөр дараах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо гүйцэтгэхээр байна.

- Бүртгэх /Хуулийн төслийн 9 дүгээр зүйл, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт/
- Хяналт тавих /Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт/

2021 оны 2 дугаар улирлын байдлаар Монгол Улсад нийт 11 арилжааны банк, 536 банк бус санхүүгийн байгууллага, үүнээс 457 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа

⁷Бүртгэлийн нэгдсэн сан байгуулахад шаардагдах санхүүжилтийн хэмжээг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д байршуулсан энэ төрлийн ажил, үйлчилгээ худалдан авах 6 урилгын үнийн дүнгийн дундаж хэмжээгээр тооцож үзэхэд 207 сая⁷ төгрөг байна. Иймд бүртгэх байгууллага нэгдсэн цахим сан үүсгэхээр байх тул тухайн санд өр барагдуулах алба нэвтэрч мэдээлэл, бүртгэлээ оруулах тул хуулийн этгээд бүр тусдаа бие даасан цахим сантай байх шаардлагагүй тул зардал гарахгүй гэж үзлээ.

⁸Электрон барааны 5 дэлгүүрийн дундаж дуу хураагуурын зах зээлийн үнийг судлав.

⁹Зургийн аппарат, камер борлуулдаг 5 дэлгүүрийн дундаж аппаратны зах зээлийн үнэд үндэслэв.

явуулж байна. Харин нийт 536 банк бус санхүүгийн байгууллагын 497 нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна. 2020 оны байдлаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч болох барьцаалан зээлдүүлэх газар 1000 гаруй байна.

2021 оны эхний хагас жилийн байдлаар иргэний хэргийн анхан шатны шийдвэрлэсэн нийт хэрэг, маргааны **50.1 хувийг** Иргэний хуулийн 281-286 дугаар зүйл дэх зээлийн гэрээний маргаан, банк болон банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээлийн гэрээний маргаан дангаараа эзэлж байх бөгөөд үүнээс **2550** нь Иргэний хуулийн 281-286 дугаар зүйл дэх зээлийн гэрээний маргаан, **1517** нь банкны зээлийн маргаан, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн маргаан **1469** буюу нийт **5536** зээлийн гэрээний маргаан иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн байна.

Эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн нийт үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний мэдээллээс харахад, 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар **23,983** үл хөдлөх хөрөнгө барьцаалагч иргэн 56,996 үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ, харин тодорхой тусгай зөвшөөрөлгүй **4137** хуулийн этгээд 91,988 барьцааны гэрээ байгуулсан байгаа нь банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, барьцаалан зээлдүүлэх газраас гадна зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй компани, байнга ашиг олох зорилгоор зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэд олон байгааг илтгэдэг.

Гэвч одоогийн байдлаар банк болон томоохон банк бус санхүүгийн байгууллага өөрийн дотоод бүтэцдээ өр барагдуулах нэгжтэй байна. Иймээс энэхүү хуулийн төсөл батлагдсанаар банк, зарим банк бус санхүүгийн байгууллагын дэргэдэх өр барагдуулах албанаас бусад /банк, банк бус санхүүгийн байгууллагын дэргэдэх өр барагдуулах дотоод бүтэц нь өр барагдуулах албаар бүртгүүлэх шаардлагагүй/ хэдэн хуулийн этгээд өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр бүртгүүлэх нь тодорхойлох боломжгүй байх тул тохиолдлын тоог гаргахдаа аргачлалын гарын авлагад заасны дагуу тодорхойлох боломжгүй гэж үзэж бүртгэлд хамрагдах хуулийн этгээдийн мэдээллийг *баримжаалан 100-300* хооронд гэж үзлээ.

Хүснэгт 7

Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа минут	Тохиолдлын тоо	Нийт хугацаа
Бүртгэж, цахимд байршуулах, нийтэд мэдээлэх арга хэмжээг авах	Мэдээллийг бүртгэх	Мэдээллийг хүлээн авах	10	100	2000
		Мэдээллийг нягтлах	30	100	3000
		Бүртгэх, бүртгэснээ эргэн мэдээлэх	30	100	3000
	Олон нийтэд мэдээлэх	Байршуулах	10	100	1000
		Мэдээлэх			1000

			10	100	
НИЙТ ЗАРЦУУЛАХ ХУГАЦАА					10,000 - 30,000 мин

4.2.Төрийн байгууллагад үүсэх хүний нөөцийн хэрэгцээг дээрх мэдээллүүдийг ашиглан дараах байдлаар гаргана:

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулах авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

- 1 жил = ажлын 200¹⁰ өдөр
- 1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/
- 1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу /200 х 8/ 1600 ажлын цаг буюу /1,600 х 60/ 96000 минут ажиллана гэсэн үг.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг нэг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ буюу ажлын байрны тоо гарна. Үүнийг дараахь байдлаар гаргана.

Хүснэгт 8

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Санхүүгийн зохицуулах хороо	30,000 мин	96,000 мин	0.3

Хүснэгтээс харахад дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхэд нийт **30,000 мин** зарцуулахаар байна. Үүнийг нэг ажилтан нэг жилд ажиллах ёстой стандарт 96,000 минут буюу 1600 цагт хувааж гаргавал уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд **0.3 хүний нөөцийн хэрэгцээ** шаардлагатай гэсэн тооцоолол гарч байна.

Аргачлалын 4.4.3-т заасны дагуу тохиолдлын тоог тогтоох боломжтой, тогтоох боломжгүй гэж 2 ангилна. Мөн аргачлалын 4.4.3.2-т зааснаар үргэлжилсэн шинжтэй, тасралтгүй хийгдэх ажил, үйлчилгээг тогтоох боломжгүй тохиолдлын тоонд хамааруулна. Тухайлбал, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг хэдэн жилээр үргэжлүүлэн хэрэгжүүлж болох бөгөөд энэ нөхцөлд шаардагдах хүний нөөцийг шууд баримжаалж тооцно. Иймд хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтад заасан хяналт тавих үйл ажиллагаа нь үргэлжилсэн шинжтэй тогтоох боломжгүй тохиолдол тул дээр дурдсан бүртгэх үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн **0.3** хэрэгцээн дээр нэмээд **0.7** хүний нөөцийн хэрэгцээ бий болно гэж баримжаалж, нийт **1 хүний нөөцийн хэрэгцээ** бий болно гэж үзлээ.

¹⁰Хуанлийн 365 хоногоос хөдөлмөрийн хуулинд заасан нийтээр амрах байрын өдөр, ээлжийн амралт, хагас бүтэн сайн өдөр зэргийг хасаж бодитой ажиллах өдрийг тооцно.

4.3.Гарах зардлыг урьдчилан тооцох:

Төрийн захиргааны байгууллагад буюу төрөөс гарах зардлыг урьдчилан тооцох үе шатанд:

- Хүний нөөцийн зардал /төрийн албан хаагчтай холбоотой шууд болон шууд бусаар үүсэх зардал/
- Материаллаг зардал /төрийн албан хаагчийн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардал/
- Бусад зардал /тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардал/-ыг тооцож гаргана.

А.Хүний нөөцийн зардал

Хүний нөөцийн зардлыг тооцохдоо тухайн ажил үйлчилгээ буюу үүргийг гүйцэтгэх төрийн захиргааны байгууллагын албан хаагчид зарцуулах цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал зэрэг төрөөс даадаг бүх зардлыг нэгтгэн авч үзэх ба эдгээрийн дундаж хэмжээгээр тооцож тогтооно.

Хүний нөөцийн зардлыг тооцоход нэг ажилтанд оногдох зардлыг Улсын Их Хурлын 2019 оны 18 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, Улсын Ерөнхий Прокурорын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Үндэсний статистикийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэлд Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны хянан шалгагч АА-8 зэрэглэлийн ахлах түшмэл байгааг үндэслэн Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, Улсын Ерөнхий Прокурорын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Үндэсний статистикийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын цалингийн сүлжээ, 4 дүгээр хавсралтаар баталсан шинжлэх ухааны байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ дээр үндэслэн АА-8 зэрэглэлийн 1 дүгээр шатлалд хамааруулан 838,108 төгрөг байхаар тооцов.

Мөн нэг албан хаагчид зарцуулах зардлыг тооцохдоо түүний үндсэн цалингаас гадна 1/ бүх төрлийн даатгал, 2/ хоол, унааны нэмэгдэл, 3/ ажилласан жилийн нэмэгдэл, 4/ зэрэг дэвийн нэмэгдэл, 5/ буцалтгүй тусламж, 6/ шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Эдгээрийн хэмжээг тодорхой тогтоох боломжгүй тохиолдолд нэг албан хаагчийн цалингийн дундаж хэмжээний 15%-иар нийтлэг зардлыг, 10%-иар дагалдах зардлыг, 30%-иар нэмэгдэл, урамшууллын зардлыг тооцох боломжтой юм.

Албан хаагчид 1 жилд зарцуулах цалингийн зардлын хэмжээ

Албан тушаал	Цалин-гийн зэрэглэл	Үндсэн цалин	Нэмэгдэл, урамшуулал ¹¹	Дагалдах зардал	НДШ ¹²	1 сарын цалин	12 сарын цалин
Хянан шалгагч	АА-8	838,108	251,432.4	83,810.8	106,439.716	1,279,790.92	15,357,491

Дээрх тооцооллоос харахад төрийн байгууллагуудад хуулийн төсөлд шинээр нэмэгдсэн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд шинээр 1 хүний орон тоо шинээр бий болгосноор нийт 15,357,491 /арван таван мянга гурван зуун тавин долоон мянга дөрвөн зуун ерэн нэгэн мянга/ төгрөгийн хүний нөөцийн зардал гаргахаар байна.

Б.Материаллаг зардал

Тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Тухайлбал цахилгааны зардал, техник тоног төхөөрөмжийн зардал, бичиг хэргийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал орох бөгөөд бүгд нийлээд “ажлын байрны ердийн дундаж материаллаг зардал”-ыг бүрдүүлнэ. Материаллаг зардал, ажлын байрны зардлын жишээг Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газрын нэг ажилтны нэг ажилтны материаллаг зардлыг тооцсон 2020 оны жишээгээр авав.¹³

Нэг албан хаагчид гарах материаллаг зардал

Зардлын нэр	Зардлын төрөл	Хэмжээ /төгрөг/
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	124,000
	Ном, хэвлэл авах	54,745
	Шуудан холбоо	306,812
	Нийт	485,557
Барилга, байгууламж, өрөө тасалгааны зардал	Түлш, халаалт	263,408
	Гэрэл, цахилгаан	128,239
	Цэвэр, бохир ус	599,438
	Урсгал засвар	127,752
	Газрын төлбөр	22,253
	Нийт	1,141,090
Элэгдэл, хорогдлын зардал ¹⁴	Техник, тоног төхөөрөмж ¹⁵	160,000

¹¹Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-д заасан хугацааны дундаж болон бусад шагнал, урамшууллын зардлыг нэгтгэн тооцов. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/9070?lawid=13946>

¹²Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлд үндэслэн тогтоов. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/390>

¹³Батлагдсан төсөв

¹⁴Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Үндсэнхөрөнгийн элэгдэл тооцох журам, Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдэлийн хэмжээ

¹⁵Нэг албан хаагчид хэргэлэгдэж буй техник, тоног төхөөрөмжийн үнийг дунджаар 800,000 төгрөгөөр тооцож, түүний элэгдэл хорогдлын хэмжээг ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор баталсан “Үндсэн

	Тавилга, эд хогшил ¹⁶	100,000
	Барилга, байгууламж ¹⁷	65,670
	Нийт	325,670

Дээр дурдсан зардлууд бүгд нийлээд “ажлын байрны ердийн дундаж материаллаг зардал”-ыг бүрдүүлнэ.

Хүснэгт 11

Ажлын байртай холбоотой үүсэх дундаж материаллаг зардал

Материаллаг зардал	Зардлын хэмжээ /төгрөг
Урсгал зардал	485,557
Барилга, байгууламж, өрөө тасалгааны зардал	1,141,090
Элэгдэл, хорогдлын зардал	325,670
Нийт	1,952,317

Томьёо

Ажлын байрны ердийн дундаж материаллаг зардал
=
Урсгал зардал + Барилга, байгууламж, өрөө тасалгааны тооцоот зардал + Элэгдэл хорогдлын зардал

Дээрх томъёог ашиглан төрд үүсэх материаллаг зардлыг тооцвол нэг ажилтанд 485,55 + 1,141,090 + 325,670 = **1,952,317** / нэг сая есөн зуун тавин хоёр мянга гурван зуун арван долоон/ төгрөгийн материаллаг зардал үүсэх бөгөөд үүнийг нийт **1** албан хаагчаар тооцвол **1,952,317** / нэг сая есөн зуун тавин хоёр мянга гурван зуун арван долоон/ төгрөгийн зардал гарахаар байна.

В.Бусад зардал

Бусад зардалд төрийн байгууллагаас үүрэг биелүүлэхэд буюу ямар нэгэн ажил үйлчилгээ гүйцэтгэхэд гарах зардлыг биш, харин тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардал буюу тухайлбал байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх, тусгайлсан програм хангамж боловсруулах, тендер зарлах гэх зэрэг зардал багтана.

хөрөнгийн элэгдэл, хорогдол тооцох журам, Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлыг тооцоход баримтлах хугацаа”-нд тусгаснаар 20% -иар тооцов.

¹⁶Тавилга, эд хогшлын үнийг дунджаар 1,000,000 төгрөгөөр тооцож, түүний элэгдэл, хорогдлыг ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад тусгаснаар 10%-иар тооцов.

¹⁷Барилга байгууламжийг элэгдэл, хорогдлын зардлыг Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслэлийн нийтлэг жишиг”-т заасны дагуу нэг дэс түшмэлд ноогдох ажлын өрөөний талбай 8м² талбай байна. Гэх зохицуулалтад үндэслэв. Үүнээс $2,300,000,000 \text{ төг} / 4483 \text{ м}^2 = 513,049 \text{ төг}$ нь 1м² талбайн өртөг бөгөөд 8м² талбайн өртөг нь 4,104,394 төгрөг болно. Нэг албан хаагчид оногдох талбайн өртөг 4104394 төгрөг гэж тооцоход элэгдэл хорогдол нь үүний 1,6%¹⁷ буюу 65670 төг гэж тооцов. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/annex/details/1941?lawid=2888> –

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэгт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо бүртгэлийг цахим санд оруулахаар заасан.

Бүртгэлийн нэгдсэн сан байгуулахад шаардагдах санхүүжилтийн хэмжээг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д байршуулсан энэ төрлийн ажил, үйлчилгээ худалдан авах 6 урилгын үнийн дүнгийн дундаж хэмжээгээр тооцож үзэхэд 207 сая¹⁸ төгрөг байна. Иймээс хуулийн төсөл дэх цахим бүртгэлийн сан байгуулахад шаардагдах нэг удаагийн зардлыг дээрх мөнгөн дүнгээр тооцов.

4.3.Зардлыг нэгтгэн тооцож гаргах:

Энэ үе шатанд төрийн захиргааны байгууллагаас буюу төрд үүсэх нийт зардлыг тооцож гаргана. Ингэхдээ хүний нөөцийн зардал, материаллаг зардлын нийлбэрийг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлэн тооцох ба үүн дээр бусад зардлыг нэмснээр нийт зардлын хэмжээ гарах юм.

Зардлын төрөл	Зардлын хэмжээ	Хүний нөөцийн хэрэгцээ	Нийт зардал
Хүний нөөцийн зардал	15,357,491	1	15,357,491
Материаллаг зардал	1,952,317	1	1,952,317
Бусад зардал	207,000,000	-	207,000,000
НИЙТ ЗАРДАЛ			224,309,808

Дээрх хүснэгтээс харахад хуулийн төсөлд тусгасан ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд Санхүүгийн зохицуулах хороонд **224,309,808** /хоёр зуун хорин дөрвөө мянга гурван зуун есөн мянга найман зуун найман мянга/ төгрөгийн зардал үүсэхээр байна.

4.4.Хувилбарыг нягтлах, үр дүнг танилцуулах:

Ийнхүү зардлын тооцоо хийхийн гол зорилго хуулийн төслийн хүрээнд төрийн захиргааны байгууллагад шинээр бий болж байгаа үүргээс үүдэлтэй ачааллыг хөнгөвчлөхөд оршино. Иймд эрх зүйн тухайн зохицуулалт буюу бэлтгэж буй төсөлд төрд үүсэх зардлыг хэмнэх боломж бий эсэхийг гэдгийг шалгаж үзэх нь чухал байдаг. Зардлын тооцоог хийснээр дараах үр дүнд хүрсэн болно. Үүнд:

1. Хуулийн төсөл дэх бүртгэлийг бичгээр, эсхүл цахимаар бус дан ганц цахим хэлбэрээр хийвэл дээрх төрийн байгууллагад үүсэх хүний нөөцийн зардлыг бууруулах, одоо байгаа бүтэц, орон тооны хүрээнд цахимаар бүртгэж, хяналт шалгалт хийх асуудлыг шийдвэрлэх, бүртгэх байгууллагын хоорондын уялдааг хангах, бүртгэлийн нэгдсэн байдлыг хангах, үр бүтээлтэй, түргэн шуурхай төрийн үйлчилгээг бий болгох боломжтой байна. Мөн дээр тооцоолсон цахим бүртгэлийн санг бий болгоход 207,000,000 төгрөг шаардлагатай болж байгааг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөлд заасан цахим сантай нэгтгэвэл энэхүү зардлыг хэмнэх боломжтой гэж үзэж байна.

¹⁸Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем. Эх сурвалж: <https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1579683294306>

ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹⁹ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг баримтлан зардлын тооцоог гаргалаа.

Хуулийн төсөлд тусгагдсан зардлыг тооцохын тулд бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалан авах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон бөгөөд тухай бүрт тайлбарыг оруулсан болно.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын дагуу иргэнд үүсэх зардал нь цаг хугацаагаар, хуулийн этгээдэд үүсэх зардал нь мөнгөн дүнгээр, төрийн байгууллагад үүсэх зардал нь хүний нөөцийн хэрэгцээгээр тооцогдог. Эдгээр тооцож гаргасан зардлууд дээр “бусад зардал”, “нэмэлт зардал” буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх зардлыг мөн тооцсон болно.

Хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлохдоо уг хуулийн төслөөр иргэн буюу зээлдэгч нь өр барагдуулах ажиллагааны нэг тал болсон тохиолдолд тодорхой хэмжээний хөлсийг хувийн эрх зүйн гэрээний үндсэн дээр өр барагдуулах албанд төлөхөөр байх бөгөөд үүнээс өөр зардал гарахааргүй байх тул зөвхөн шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг эрхлэх хуулийн этгээд болон төрд үүсэх зардлыг тооцсон болно.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд нийт хуулийн этгээдэд үүсэх мөнгөн зардлыг тооцох боломжгүй тул нэг хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцсон болно. Тухайлбал, бүртгүүлэхэд **3268.2 төгрөг**, улирал бүр тайлан гаргаж хүргүүлэхэд жилд **9553.2 төгрөг**, өр төлбөртэй этгээдтэй харилцахдаа дуу дүрсний бичлэг хийж, цахим санд байршуулах, баримтжуулахад нэг удаад **1508.4 төгрөг**, өрийн тохиролцоо хийхэд нэг удаад **1587.5 төгрөг**, нэмэлт зардал болох дуу хураагуур, зургийн аппаратад нэг хуулийн этгээдэд **1,800,000** төгрөгийн зардал гаргахаар байна. Гэхдээ өр барагдуулах алба нь нэгэнт цахим бүртгэлд гэрээ, холбогдох бүхий л материалыг тухай бүр оруулах үүрэгтэй байх тул улирал бүр тайлан гаргаж хүргүүлэх нь ач холбогдолтой эсэхийг нягталж, хэрэв шаардлагагүй гэж үзвэл хуулийн этгээд нь жилд **9553.2 төгрөгийг** хэмнэх боломжтой юм.

Хуулийн төсөл нь улсын төсөвт 1 хүний нөөцийн зардал үүсгэхээр тооцоолол гарсан болно. 1 хүний нөөцийн зардал Санхүүгийн зохицуулах хороонд гарахаар байх бөгөөд оногдох зардал нь жил бүр **17,309,808** төгрөг байна. Гэхдээ энэхүү зардлыг бууруулах буюу одоо байгаа бүтэц орон тоогоор шийдвэрлэх боломжтой байна гэж дүгнэсэн болно.

¹⁹Хууль тогтоомжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

Тодруулбал, цахим бүртгэлийн сан бий болгох зардал болох **207,000,000** төгрөг буюу нэг удаад үүсэх зардал үүсэхээр байна. Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн этгээд нь өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэгчээр бүртгүүлэхдээ бичгээр, эсхүл цахимаар өргөдөл гаргахаар, мөн зүйлийн 9.8 дахь хэсэгт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо бүртгэлийг цахим санд оруулахаар заасан. Тэгвэл бичгээр гэснийг хасаж, зөвхөн цахимаар бүртгэдэг байхаар зохицуулбал бичгээр ирүүлснийг цахим санд оруулах бүртгэлийн нэмэлт ажил үүсэхгүй тул хүний нөөцийн хэрэгцээ буурч болно.

Мөн Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл²⁰ батлагдсаны дараа мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлийн нэгдсэн цахим бүртгэлийн сангийн нэг хэсэг байхаар нэгтгэж программ хангамжийг нь шийдвэл Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл дэх бүртгэлийн цахим санг үүсгэх 207,000,000 төгрөгийн нэг удаагийн зардлыг хэмнэх боломжтой юм.

Хуулийн төсөл батлагдснаар хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын үр өгөөж нь үүсэх зардлаас их байна. Учир нь хуулийн төсөл батлагдсанаар дараах үр өгөөжийг бий болгохоор байна. Үүнд:

Зээлдүүлэгч, тэдгээрийн өөрсдийн бүтцийн өр барагдуулах алба (жиш. банкны дэргэдэх өр барагдуулах алба г.м) болон бүртгэлтэй өр барагдуулах албаны өр нэхэх, барагдуулах үйл ажиллагаанд зүй зохистой стандарт тогтоох, зээлийн үлдэгдлийг нэхэхдээ зээлдэгчийн бусад эрхэд халдахгүй байх, түүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх;

Шүүхийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд цаг хугацаа, шууд болон шууд бус олон төрлийн зардал гардаг бол шүүхийн өмнөх шатанд өр барагдуулах албыг альтернатив байдлаар ашигласнаар зардал, цаг хугацааг хэмнэх боломж бүрдэх;

Зээлдүүлэгч, зээлдэгч нар харилцан тохиролцож өрийн тохиролцоо (debt settlement, debt adjustment) хийх, аль болох шүүхэд очихгүй байх боломжийг олгох уян хатан, хэрэгжих боломжтой, харилцан ашигтай тогтолцоог бий болгож, улмаар санхүүгийн зах зээлийн хувьд мөнгөний эргэлт удаан хугацаанд түгжигдэхгүй байхад эерэгээр нөлөөлөх;

Зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, эсхүл бүртгэлгүй этгээд байнга, ашиг олох зорилгоор зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг байдлыг бууруулах түлхэц болох;

Шүүхээс өмнөх шатанд гэрээний талууд өрийн тохиролцоог дахин уян хатнаар хийх, зээлийн гэрээний үүргийг үр дүнтэй хангуулах, улмаар шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад үүсч болзошгүй ачааллыг бууруулах;

Өр барагдуулах алба бий болсноор бизнесийн шинэ төрөл үүсч, ажлын байр шинээр бий болж, эдийн засагт эерэгээр нөлөөлнө.

-----oOo-----

²⁰Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл <http://forum.parliament.mn/projects/11015>

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ:

I.Хууль тогтоомж, эрх зүйн акт

- 1.Хууль тогтоомжийн тухай хууль
- 2.Хөдөлмөрийн тухай хууль
- 3.Нийгмийн даатгалын тухай хууль
- 4.Засгийн газрын 2016 оны 59 дүгээр торгтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал"

II.Бусад ашигласан материал

- 1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал
- 2.Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл /2021 оны 07 дугаар сарын байдлаарх/
- 3.Хуулийн төслийн таницлуулга
- 4.Банк, банк бус санхүүгийн байгууллагын талаарх статистик мэдээлэл
- 5.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл, Монголбанк, 2020 он.
- 6.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл

III. Интернэт эх сурвалж

- 1.<http://www.legalinfo.mn>
- 2.Үндэсний статистикийн хорооны www.nso.mn веб хуудас
3. <https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1579683294306>
4. <http://www.legalinfo.mn/annex/details/1941?lawid=2888> –
5. <https://www.legalinfo.mn/annex/details/9070?lawid=13946>